


Захирлын 2014-оны 05 дугаар сарын 27-ны
өдрийн 154 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



МУИС-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДЭХ БАГШИЙН ТӨЛӨӨЛЛИЙН НӨХӨН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Удирдах зөвлөл дэх багшийн төлөөллийг сонгох үйл ажиллагааг хоёр үе шаттай зохион байгуулна. Үүнд:

1. Бүрэлдэхүүн сургуулиудаас нэр дэвшүүлэх
2. МУИС-ийн нийт багш нарын санал хураалт явуулах

НЭГ. Эхний шатны санал хураалт
/Бүрэлдэхүүн сургуулиас багшийн төлөөлөл сонгох/

Бүрэлдэхүүн сургуулийн нийт багш нарын хурлыг 2014 оны 5 дугаар сарын 30-ны дотор багтаан зохион байгуулна.

Хурлын зохион байгуулалт

- Бүрэлдэхүүн сургуулийн захиргаа бүх багш нарын хурлыг зарлана.
- Хуралд оролцогчдоос 3-5 багшийн бүрэлдэхүүнтэй комисс сонгож хурлыг удирдуулна. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын туслах хурлын тэмдэглэл /аудио бичлэгийн хамт/ бичнэ.
- Хуралд бүрэлдэхүүн сургуулийн үндсэн багш, зөвлөх профессор, ЭША оролцоно. /МУИС-ийн Дүрмийн 4.1.1, 4.1.2/
- Хурал үндсэн багш нарын 2/3-оос доошгүй ирцтэй байж хүчинтэйд тооцогдоно.
- Хурлаас бүрэлдэхүүн сургуулиас МУИС-ийн Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх багшийг тодруулна.
- Бүрэлдэхүүн сургуулийн тэнхим, лаборатори, багш удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх эрхтэй.
- Нууц санал хураалтыг зохион байгуулах тооллогын комисс томилно.
- Нууц санал хураалтаар хамгийн олон санал авсан багшийг дараагийн шатны сонгуульд оруулах тухай тооллогын комиссын тогтоол гарна.
- Хурлын тэмдэглэл, санал хураалтын дүнг баталгаажуулсан тооллогын комиссын тогтоол, хуралд оролцсон багш нарын нэрсийн жагсаалтыг 2014 оны 05 дугаар сарын 30-ны дотор ЗХШҮА-д ирүүлнэ.

Нэр дэвшигчид тавигдах шаардлага


- МУИС-ийн үндсэн багш байх.
- МУИС-д /Шинжлэх ухаан, боловсролын салбарт/ 5-аас доошгүй жил ажилласан байх.
- Ашиг сонирхолын зөрчилгүй байх. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д заасны дагуу Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан нь хувийн хэвшлийн сургуультай, ижил чиг үүрэг бүхий хувийн хэвшлийн байгууллагад давхар алба хашдаг байж болохгүй.

ХОЁР. МУИС-ийн багш нарын санал хураалт

МУИС-ийн хичээлийн 1-р байрны 206 тоот өрөөнд 2014 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 10.00-17.00 цагт МУИС-ийн бүх багш нарын санал хураалт явуулна.

- Бүрэлдэхүүн сургуулиудаас нэр дэвшсэн багш нарын товч танилцуулгыг нэгдсэн загварын дагуу бэлтгэн МУИС-ийн веб хуудас болон санал хураалт явуулах байрны үүдэнд /хичээлийн 1-р байрны 2-р давхрын вестибюльд/ байршуулна.
- ЗХШҮА-аас санал хураалтад оролцох багш нарын нэрсийн жагсаалт гаргана.
- Санал хураалтад МУИС-ийн үндсэн бүх багш, зөвлөх профессорууд оролцоно.
- Нэр дэвшсэн багшаас хамгийн олон санал авсан 5 багшийг МУИС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосонд тооцно.

Захирлын 2014 оны 05 дугаар сарын 27-ны
өдрийн 19 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Бүрэлдэхүүн сургуулиас Удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх багшийн тоо

1. Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбар	2
2. Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар	2
3. Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар	2
4. Бизнесийн сургууль	2
5. Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	1
6. Хууль зүйн сургууль	1
7. Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	2
8. Завхан сургууль	1
9. Орхон сургууль	1
Нийт	14